



**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

Засгийн газрын VII байр, Энхтайваны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим шуудан: info@mod.gov.mn
Цахим хаяг: www.mod.gov.mn

2026 01 09 № 03/156
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 онд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх тайлан, шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийсэн дүгнэлт, сайдын зөвлөлөөр хэлэлцүүлсэн хуралдааны тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 1/1 хуудастай.

Жич: Яамны Төрийн нарийн бичгийн дарга гадаад улсад албан томилолтоор ажиллаж байгаа болно.

СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.ГАНДИРВАА



Батлан хамгаалах яамны 2026 оны
01.. дугаар сарын 09-ны өдрийн
03/136... дугаар албан бичгийн хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ИРГЭД, АЛБА ХААГЧДААС
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН 2025 ОНЫ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/90 дүгээр тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах яаманд цэргийн алба хаагч, бэлтгэл болон чөлөөнд гарсан офицер, ахлагч, ажилтан, албан хаагчид, иргэдээс хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан “Батлан хамгаалах-Иргэний хяналтын тусгай дугаарын ашиглалтын журам”-ыг тус тус мөрдлөг болгон салбарын хэмжээнд цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч тусгай бүртгэлд бүртгэн, хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэн, холбогдох хариуг хүргүүлэн ажилласан талаар дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

Нэг. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл,
гомдлыг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 онд иргэд, алба хаагчдаас нийт 15222 өргөдөл, гомдол ирснээс 15057 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа, хугацаа болоогүй 165 өргөдөл байгаа болно. (Үүнээс Батлан хамгаалах яаманд 65, ЗХЖШ болон харьяа командлал, нэгтгэл, ангид 87, яамны харьяа байгууллагад 13 өргөдөл)



Албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг дараах сувгуудаар хүлээн авч, ажилласан. Үүнд:

1. Батлан хамгаалах яаманд биечлэн;
2. 11458929 дугаарын утсаар;
3. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс цахим хэлбэрээр;
4. Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар;
5. Цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан, шийдвэрлүүлж, хариуг хүргүүлсэн.

2025 онд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- 13532 буюу 88.9 хувь нь бичгээр (биечлэн);
- 95 буюу 0.6 хувь нь ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөр;
- 360 буюу 2.4 хувь нь “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаар, мөн өргөдөл, гомдол хүлээн авах 11458929 дугаар болон бусад дугаараар;
- 104 буюу 0.7 хувь нь веб сайт, аппликэйшн, сошиал флатформ, и-мэйлээр;
- 1131 буюу 7.4 хувь нь ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирсэн байна.

Өргөдлийг агуулгаар нь ангилбал:

1. Нийгмийн хамгааллын асуудлаар 5782 буюу 38 хувь;
2. Ажлын байртай холбоотой асуудлаар 7420 буюу 48.7 хувь;
3. Гадаад, дотоодын их, дээд сургууль, академи, дамжааны сонгон шалгаруулалтад хамрагдах болон суралцахыг хүссэн асуудлаар 572 буюу 3.9 хувь;
4. Бусад 1448 буюу 9.4 хувийг тус тус эзэлж байна.

Ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн дийлэнх буюу 86.7 хувийг цэргийн алба хаагчид, цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл болон чөлөөнд байгаа иргэд, ажилтнуудаас ирүүлсэн ажлын байр, нийгмийн хамгааллын асуудлаар хандсан өргөдөл эзэлж байна.

Нийгмийн хамгааллын асуудлаа шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдлийг судлан үзэхэд тодорхой хугацаа шаардсан, тухай бүрд нь шийдвэрлэхэд хүндрэлтэй (орон сууц олгуулах, орон сууцны урьдчилгааны мөнгөн дэмжлэг хүссэн, хөнгөлөлттэй үнээр орон сууц олгох, хувьчлахыг хүссэн болон мөнгөн дэмжлэг үзүүлэхийг хүссэн г.м) өргөдлүүд эзэлж байна.

Орон сууцны жагсаалтад бүртгэж өгөхийг хүссэн алба хаагчдын өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, дараалалд оруулах арга хэмжээг авч, хариуг хүргүүлэн ажиллаж байна.

Хоёр. Батлан хамгаалах яаманд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байдлын талаар:

Батлан хамгаалах яамны удирдлагад хандаж иргэдээс 2025 онд 967 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 902 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна.

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа, хугацаа болоогүй 65 өргөдлийг харьяа байгууллага, тухайн асуудал хариуцсан албан тушаалтанд шилжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг албан тушаалтнуудад хандаж гаргасан байдлаар нь харьцуулбал:

- | | |
|--|---|
| • Батлан хамгаалахын сайдад | 247 буюу 33,1 хувь; |
| • Төрийн нарийн бичгийн даргад | 207 буюу 24,6 хувь; |
| • Батлан хамгаалах яамны Ёс зүйн дэд хороонд | 4 буюу 0,4 |
| • Төрийн захиргааны удирдлагын газрын даргад | 138 буюу 11,8 хувь; |
| • Батлан хамгаалах яам болон бусад албан тушаалтнуудад | 371 буюу 30,1 хувийг тус тус эзэлж байна. |

Гурав. “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын **1800-1144** тусгай дугаар, өргөдөл, гомдлын **11458929** дугаарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдлын талаар:

“Батлан хамгаалах-Иргэний хяналт” 1800-1144 тусгай дугаарт батлан хамгаалах, зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн жинхэнэ алба хаагчидтай холбоотой бүхий л төрлийн санал, хүсэлт, мэдээллийг 24 цагийн турш хүлээн авч ажиллаж байна.

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 1800-1144 тусгай дугаараар-240, 11458929 дугаараар-120, нийт-360 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирснийг бүрэн шийдвэрлэсэн.

Тус тусгай дугаарт иргэдээс ирсэн дуудлага, мэдээлэл, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг Төрийн захиргааны удирдлагын газраас 14 хоног тутамд нэгтгэн Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид танилцуулан, холбогдох арга хэмжээг шуурхай авч, ажиллаж байна.

Дөрөв. Бусад байгууллагаас харьяаллын дагуу уламжлагдан ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Ерөнхийлөгчийн Тамгын газар болон бусад байгууллагуудаас 2025 онд нийт 71 өргөдөл, гомдол шилжин ирснийг судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгч ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 24;
- Монгол Улсын Их хурлын Байнгын хорооноос 2;
- Монгол Улсын Их хурлын гишүүнээс 4;
- Монгол Улсын Засгийн газраас 5;
- Бусад байгууллагаас 36 өргөдөл, гомдол ирсэн байна.

Тав. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байдлын талаар:

2025 онд Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс 95 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал хуваарилагдан ирснийг тухай бүрд нь хүлээн авч холбогдох арга хэмжээг авч, хариуг 100 хувь өгч ажилласан.

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- 68 буюу 71.6 хувь нь утсаар;
- 2 буюу 2.1 хувь нь биечлэн;
- 4 буюу 4.2 хувь нь и-мэйлээр;
- 21 буюу 22.1 хувь нь цахимаар тус тус ирсэн байна.

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг утгаар нь ангилбал:

- 45 буюу 47.4 хувь нь гомдол;
- 8 буюу 8.4 хувь нь санал;
- 18 буюу 19 хувь нь талархал;
- 24 буюу 25.2 хувь нь хүсэлт тус тус эзэлж байна.

Зургаа. Байлдаанд оролцсон ахмад дайчид, тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмад дайчид, тэдгээрийн гэр бүлээс ирүүлсэн хүсэлтийг судлан нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдлын талаар:

Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон гавьяат цолтон, Төрийн шагналт, Төрийн соёрхолт, Ахмад дайчин, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан (1990-1992 он) Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүдэд сар бүр нэмэгдэл олгодог.

Дээрх хуулийн зохицуулалтад заасны дагуу ахмад настуудад харьяалах салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусган баталсны дагуу 2025 оны 12 сарын байдлаар Батлан хамгаалах салбарын харьяаны 46 алдар цолтон, ахмад настуудад нэмэгдэл мөнгөн дэмжлэгийг сар бүр олгож байна.

Долоо. Өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах шийдвэрлэх хугацааг, багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд нь хариуг өгөхөд анхаарал хандуулан ажиллалаа.

Иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг богино хугацаанд утсаар мэдэгдэх эсвэл албан бичгээр хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд биечлэн уулзаж өргөдөл, гомдлын хариуг аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 оны I улирал, эхний хагас жил, III улиралд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн тайланг Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn цахим хаягт тухай бүр байршуулж хэвшсэн.

Иргэдээс Батлан хамгаалах яам, удирдах албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт гаргах, шийдвэрлэлтийн үйл явцыг хянах зорилгоор

өргөдөл, гомдлын бүртгэлийг цахим систем (Able soft программ)-д шилжүүлэн иргэд, алба хаагчидтай эргэх холбоотойгоор ажиллаж байна.

Найм: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийсэн байдал:

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалаар батлагдсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 онд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийлээ.

“Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын 4.1.1-д “хуулийн хугацаанд ирүүлсэн, хугацаа хоцроож ирүүлсэн, тайлан, мэдээ зөрүүтэй тайлагнасан болон мэдээ ирүүлээгүй нэгжийн мэдээллийг тусгана” гэснийг нягтлахад Батлан хамгаалах яамны харьяа 16 байгууллагаас өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 2025 оны шийдвэрлэлтийн тайланг ирүүлсэн байна.

Мөн журмын 4.1.2-д “өргөдөл, гомдлыг эрх зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн эсэх, шийдвэрлэлтийн талаар өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдсэн эсэх, мэдэгдсэн хэлбэрийг тусгана” гэснийг тодрууллаа.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4-т “Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээ авсан тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ.” гэж зааснаар Батлан хамгаалах яам нь өргөдөл, гомдол гаргасан алба хаагч, иргэний хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл албан бичгийн аль тохиромжтой хэлбэрийг сонгон ажилласан байна.

Мөн дээрх хуулийн 15 дугаар зүйлийн 5-д “Хариуг амаар, харилцах утсаар мэдэгдсэн бол энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.” гэсний дагуу хариуг хэрхэн мэдэгдсэн талаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн бүртгэлд тэмдэглэл хөтөлж хэвшсэн байна.

Батлан хамгаалах салбарт 2025 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлоос шийдвэрлээгүй болон хангалтгүй шийдвэрлэлттэй өргөдөл, гомдлын учир шалтгаанд дүн шинжилгээ хийхэд дайнд оролцсон ахмад дайчдын үр хүүхдүүд болон алба хаагчдаас орон сууцны дэмжлэг хүссэн өргөдлийг төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан шийдвэрлэх боломжгүй (шийдвэрлэлт хангалтгүй) өргөдлүүд эзэлж байна.

Дайнд оролцсон ахмад дайчдын нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг дээшлүүлэхтэй холбогдуулан төрөөс дараах эрх зүйн баримт бичгийг баталсан бөгөөд дээрх эрх зүйн баримт бичгүүдэд нас барсан ахмад дайчдын гэр бүл, үр хүүхдэд орон сууц болон түүнтэй адилтгах мөнгөн тусламж үзүүлэх зохицуулалт тусгагдаагүй байх тул орон сууцны дэмжлэг үзүүлэх боломжгүй болно. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны “Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 170 дугаар зарлиг;

2.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц эсхүл түүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн тусламж олгох тухай” 72 дугаар тогтоол;

3.Засгийн газрын 2009 оны “Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай” 212 дугаар тогтоол;

4.Засгийн газрын 2012 оны “Ахмад дайчинд орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай” 198 дугаар тогтоол зэрэг болно.

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тайланг өмнөх онтой харьцуулахад 7335 өргөдлөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь харьяа агентлаг, нэгтгэл, ангиудын алба хаагчдын ажлаас чөлөөлөгдөх, өөр албан тушаалд шилжүүлэх, сургалт, дамжаанд хамрагдахыг хүссэн, чөлөө хүссэн, хөдөлмөрийн дотоод журамд заасан тусламж, дэмжлэг үзүүлэхийг хүссэн өргөдлүүд нийт ирсэн өргөдөл, гомдлын дийлэнх хувийг эзэлж байгаагаас шалтгаалж байна.

Дүгнэлт:

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 онд иргэд, алба хаагчдаас нийт 15222 өргөдөл, гомдол ирснээс 15057 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилт 98.9 хувьтай байна.

2025 онд Батлан хамгаалах салбарт алба хааж буй цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан, албан хаагчид иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэл хөтлөн, хариуг хуулийн хугацаанд түргэн шуурхай өгч ажилласан байна.

Санал:

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалаар батлагдсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам” батлагдсантай холбогдуулан 2026 оны I улиралд багтаан харьяа агентлаг, анги, байгууллагуудын өргөдөл, гомдол хариуцсан албан тушаалтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах;

Тулгамдаж буй асуудал:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй” гэж, мөн зүйлийн 4-т “Өргөдөл, гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа.” гэж тус тус заасан боловч зарим иргэдээс шүүхээр шийдвэрлэгдсэн асуудлаар болон өмнө нь удаа дараа хандаж, холбогдох хариуг авч байсан асуудлын талаар олон дахин, тогтмол давтамжтай өргөдөл, гомдол, хүсэлтийг гаргаж байгаагаас ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлж байна.

2025 ОНЫ ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ 1

2025 оны жилийн эцсийн байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл			Гомдол	Дүн	Хүлээн авсан хэлбэр					Дүн
	Хүсэлт	Санал	Мэдэгдэл			Биечлэн	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
Батлан хамгаалах салбарын хэмжээнд	14846	321		55	15222	13532	360	104	95	1131	15222

2024 оны жилийн эцсийн байдалтай харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл			Гомдол	Дүн	Хүлээн авсан хэлбэр					Дүн
	Хүсэлт	Санал	Мэдэгдэл			Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
Батлан хамгаалах салбарын хэмжээнд	7730	36	2	119	7887	7204	157	221	177	128	7887

МЭДЭЭ ГАРГАСАН:

АХМАДЫН БОДЛОГО,
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/Албан тушаал/

АХМАД М.САРУУЛГЭРЭЛ

/Нэр/



/Гарын үсэг/

2026 оны 01 сарын 29 өдөр

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ 2

2025 оны жилийн эцсийн байдлаар

Байгууллагын нэр	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
Батлан хамгаалах салбарын хэмжээнд	6259	61	424	8161	151			1	165	

2024 оны жилийн эцсийн байдалтай харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
Батлан хамгаалах салбарын хэмжээнд	4907	213	245	2203	218	2			99	

МЭДЭЭ ГАРГАСАН:

АХМАДЫН БОДЛОГО, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/Албан тушаал/

АХМАД М.САРУУЛГЭРЭЛ

/Нэр/



/Гарын үсэг/

2026 оны 01 сарын 09 өдөр

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ 3

Хамгийн их ирүүлсэн өргөдөл гомдлыг ангилан топ 5-ыг авах

Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
Нийгмийн хамгааллын асуудлаар	5782	38%	Алба хаагчдын чөлөө хүссэн, ээлжийн амралтаа хугацаанаасаа өмнө эдлэхийг хүссэн, хугацаат цэргийн албанаас хугацаанаас өмнө чөлөөлөгдөх, хоногийн чөлөө хүссэн өргөдөл дийлэнх хувийг эзэлж байна.
Ажлын байртай холбоотой асуудлаар	7420	48,7%	Нэгтгэл, анги, байгууллага, салбарт ажиллахыг хүссэн, шилжин томилогдохыг хүссэн, цэргийн тэтгэвэрт гарах, алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах хүсэлтүүд эзэлж байна.
Сургалттай холбоотой асуудлаар	572	3,9%	Дотоод, гадаадын академи, сургууль, дамжаа болон гадаад хэлний дамжааны сонгон шалгаруулалтад хамрагдах, суралцах хүсэлтүүд эзэлж байна.
Ахмад дайчинтай холбоотой асуудлаар	64	0,4%	Ахмад дайчид болон тэдний ар гэр, үр хүүхдүүдээс орон сууцны дэмжлэг, мөнгөн тусламж, бусад төрлийн тусламж, дэмжлэг хүссэн өргөдөл эзэлж байна.
Бусад асуудлаар	1384	9%	Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаарх санал болон их дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах, ар гэрийн гачигдлаар хугацаат цэргийн албанаас чөлөөлөгдөх өргөдлүүд эзэлж байна.
Нийт	15222	100%	


МЭДЭЭ ГАРГАСАН:

АХМАДЫН БОДЛОГО, ӨРГӨДӨЛ,
ГОМДОЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

/Албан тушаал/

АХМАД М.САРУУЛГЭРЭЛ

/Нэр/



/Гарын үсэг/

2026 оны 01 сарын 08 өдөр